

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ

2025 оны 02 сарын 06 -ны өдөр

Дугаар.....

БА-044/2025

Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хороонд баригдсан дунд төвөгшилтэй ангиллын зорьгүй 1-3 давхар, 4 блок, 210.0м*60.0м, 12600.0мкв хүчин чадалтай агуулахын зориулалттай барилга, зорьгүй 1 давхар, 28.0м*12.0м, 336.0мкв хүчин чадалтай уурын зуухны барилга байгууламжид Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дугаар захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 14 гишүүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1 Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний 2023/06/23 огноо; БАЗГ2023/370 №0013021 дугаар;

2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар: UR.CD22-10

2.3. Захиалагч: Эл Би Урбан Товер ХХК оноосон нэр, 9011410114 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5710898 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Залуучуудын өргөн чөлөө -13380, Сөүл Бизнес Төв, 6 давхар, 99114996 холбоо барих утас,

2.4. Барилгын ажлын ерөнхий гүйцэтгэгч: Титан манлай ХХК оноосон нэр, 9011410109 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5710766 регистрийн дугаар, БУ11-464/16 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 3 дугаар хороо, 2 хороолол, 63-40 тоот 91000058, 99101707 холбоо барих утас, titanmanlaillc2013@yahoo.com цахим хаяг;

2.5. Барилгын туслан гүйцэтгэгч байгууллага: Нягт холбоос констракшн ХХК оноосон нэр, 9011115065 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5155398 регистрийн дугаар, БУ16-509/24 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 3 дугаар хороо, Вояж зочид буудал 500 тоот, 88093929 холбоо барих утас;

Рижид констракшн ХХК оноосон нэр, 9011849729 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 8327955 регистрийн дугаар, БУ12-01/24 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар,

Хаяг: Баянзүрх дүүрэг, Залуучуудын өргөн чөлөө -13380, Сөүл Бизнес Төв, 6 давхар, 94093454 холбоо барих утас,

Дрийм санитари ХХК оноосон нэр, 9011231077 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5375207 регистрийн дугаар, БУ12-30/24 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар,
Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 2 дугаар хороо, цэргийн хотхон 8-245 тоот 91904411;

Сапалын электрикс ХХК оноосон нэр, 9011851024 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 8345597 регистрийн дугаар, БУ18-23/24 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар,
Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 19 дүгээр хороо, үйлдвэр, туул гол 95 – 13 тоот, 99074938 холбоо барих утас;

Хар шонхор илч ХХК оноосон нэр, 9011450014 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5776589 регистрийн дугаар, БУ12-167/24 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар,
Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 8 дугаар хороо, Эрдэнэ толгой, 40 Дан 1 тоот, 80117884 холбоо барих утас;

Хаш контакт ХХК оноосон нэр, 9011340012 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5570824 регистрийн дугаар, БУ12-341/24 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар,
Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 2 дугаар хороо, их тойруу-2, 1-р гудамж 16Б холбоо барих утас;

Мандах гэрэл дөл ХХК оноосон нэр, 9011834097 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 60792065 регистрийн дугаар, 2274/23 ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар,
Хаяг: Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 37 дугаар хороо, Содон, үйлдвэрчний эвлэл 104-98, 99990421, 89098850 холбоо барих утас,

2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: Юнирүүтс ХХК оноосон нэр, 9011394043 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5675898 регистрийн дугаар, ЗТ18-1457/18 зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар,
Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Нарны зам, Юнион бьюлдинг, 907 тоот, 99007641 холбоо барих утас;

2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: Эл Би Урбан Товер ХХК оноосон нэр, 9011410114 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5710898 регистрийн дугаар,
Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Залуучуудын өргөн чөлөө -13380, Сөүл Бизнес Төв, 6 давхар, 99114996 холбоо барих утас,

2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: Шаардлага хангасан.

Гурав. Дүгнэлтийн хэсэг

- ✓ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:
 - Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул
- Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:
 - Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул
 - Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1. Дунд төвөгшилтэй ангиллын зоорьгүй 1-3 давхар, 4 блок, 210.0м*60.0м, 12600.0мкв хүчин чадалтай агуулахын зориулалттай барилга, зоорьгүй 1 давхар, 28.0м*12.0м, 336.0мкв хүчин чадалтай уурын зуухны барилга байгууламж түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэ барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад ... хоногийн дотор багтаан шилжүүлэх;

б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

3.3. Ашиглагч байгууллагад:

а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;

б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;

в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.


3.4. Комиссын акт 4 хуудас, хуралдааны тэмдэглэл 5 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 28 хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1. Дунд төвөгшилтэй ангиллын зоорьгүй 1-3 давхар, 4 блок, 210.0м*60.0м, 12600.0мкв хүчин чадалтай агуулахын зориулалттай барилга, зоорьгүй 1 давхар, 28.0м*12.0м, 336.0мкв хүчин чадалтай уурын зуухны барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хороо, Эл Би урбан товер ХХК-ийн захиалгатай агуулах, уурын зуухны барилга

Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч




(А.Мөнгөн)

Нарийн бичгийн дарга:
Эл Би урбан товер ХХК-ийн захирал



(Д.Энхтүвшин)

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН 32 ДУГААР ХОРОО, ЭЛ БИ УРБАН ТОВЕР ХХК-ИЙН ЗАХИАЛГАТАЙ ЗООРЬГҮЙ 1-3 ДАВХАР, 4 БЛОК, 210.0М*60.0М, АГУУЛАХЫН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр

Улаанбаатар хот

Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хороо, Эл Би Урбан Товер ХХК-ийн захиалгатай дунд төвөгшилтэй ангиллын зоорьгүй 1-3 давхар, 4 блок, 210.0м*60.0м, 12600.0мкв хүчин чадалтай агуулахын зориулалттай барилга, зоорьгүй 1 давхар, 28.0м*12.0м, 336.0мкв хүчин чадалтай уурын зуухны барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын хуралдаан тус барилгын 3 дугаар давхрын хурлын танхимд 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр 09:00 цагт 14 гишүүний бүрэлдэхүүнтэй эхэлж, 11:00 цагт дуусав.

Хуралд:

- | | | |
|----|---|---|
| 1 | Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч | ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ГАЗАР
Барилга байгууламжийн ашиглалтад оруулах комисс
Б.Батчимэг
Д.Энхтүвшин |
| 2 | Комиссын нарийн бичгийн дарга: “Эл Би Урбан Товер” ХХК-ийн захирал | |
| 3 | Хяналт шалгалтын газрын Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч | Г.Батбаатар |
| 4 | Хяналт шалгалтын газрын Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч | Э.Цогзолмаа |
| 5 | Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК Техник хяналтын хэсгийн ахлагч | Б.Дашдорж |
| 6 | Ус сувгийн удирдах газар, Хэрэглэгчдэд үйлчлэх албаны менежер | Г.Үүрийнгэгээ |
| 7 | “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХК-ийн Технологийн удирдлага төлөвлөлтийн газар Дэд бүтэц төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн | М.Жаргалан |
| 8 | Онцгой байдлын ерөнхий газрын Барилгын зураг төслийн хяналтын ахлах байцаагч, Ахмад | Б.Дөл-Эрдэнэ |
| 9 | Барилга хөгжлийн төв, Барилга, барилгын материал үйлдвэрлэлийн хэлтэс, Барилгын зураг төслийн хяналтын ахлах байцаагч, | Д.Батням |
| 10 | Үндэсний төв архив, Зураг төслийн баримтын архивын ахлах архивч | Э.Шижиртуяа |
| 11 | Ашиглагч байгууллагын төлөөлөл Эл Би Урбан Товер ХХК-ийн менежер | М.Одонхүү |
| 12 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллагын төлөөлөл | Б.Ганбаатар |
| 13 | Зураг төслийн “Юнирүүтс” ХХК-ийн захирал | С.Бекжан |

ИРЦИЙН БАЙДАЛ

- Мэдэгдэл хүлээн авсан – 14
- Хуралд оролцож үүрэг даалгаврын биелэлтээр санал гаргасан – 14

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хороо, Эл Би Урбан Товер ХХК-ийн захиалгатай зорьгүй 1-3 давхар, 4 блок, 210.0м*60.0м агуулахын зориулалттай барилга, зорьгүй 1 давхар, 28.0м*12.0м уурын зуухны барилга байгууламжийн барилгын ажлын гүйцэтгэл ашиглалтад оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

СОНССОН НЬ:

Комисст ажилласан гишүүд барилга байгууламжийн зураг төсөл, баримт бичиг, барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж танилцаад дараах саналуудыг гаргав.


Хяналт шалгалтын газрын Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч **Г.Батбаатар:**

- Зураг төсөл зохиогчийн тусгай зөвшөөрөл үзүүлэх
- Барилгад хэрэглэсэн бетоны шинжилгээг үе шат бүрээр үзүүлэх. А, Б, С блок
- Барилгад хэрэглэсэн арматурын шинжилгээг үзүүлэх
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан 00-д тоноглол хийх.
- Барилгад хэрэглэсэн материал, цонх, хаалганы сертификат тохирлын гэрчилгээг үзүүлэх монгол хэл дээр.
- Зурагт өөрчлөлт оруулсан гүйцэтгэлийн зургийг баталгаажуулж үзүүлэх
- Барилгын ажил үргэлжлүүлэх зөвшөөрөл үзүүлэх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Хяналт шалгалтын газрын Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч **Э.Цогзолмаа:**

- Уурын зуухны барилгын гадна түлш хадгалах агуулах, үнс хадгалах агуулахтай болох
- Уурын зуухны барилга дотор байрлах дулааны узелийг бүрэн хаягжуулах
- Уурын зуухыг паспортыг бүртгэлжүүлэх
- Гадна дулааны худагт шатны бэхэлгээг хийж, цэвэрлэх, шугам сүлжээг өнгийн туузаар ороох
- Дулааны зангилаа 1,2,3,4-г бүрэн хаягжуулж, хаалт хамгаалалт хийх
- Оффисын өрөөний халаах хэрэгслүүд дээр термостат суурилуулах
- Хаягдал утааны хэмжилт хийж, дүнг баталгаажуулах
- Оффисын өрөөнүүдийн, 00-ийн АС-г бүрэн угсарч дуусгаж баталгаа албан тоот илүүлэх
- Уурын зуухны шугам угсралтын ил далд акт бүрэн баталгаажуулах
- Дотор халаалтыг угсарсан ил далд акт баталгаажуулах



- Салхивч угсарсан ил далд акт баталгаажуулах
Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн техникийн хяналтын инженер

Б. Дашдорж:

- Гадна цахилгааны цахилгаан дамжуулах агаарын шугамын трасс өөрчилсөн зөвшөөрөл ажлын зураг холбогдох бичиг баримт ирүүлэх
- Цахилгаан үүсгүүр дизель генераторыг харьяа засварын төвд бүртгүүлэх
- 0.4Кв-ийн ерөнхий шийтний хамт бичлэг виркжүүлэлт хийх /схем байршуулах/
- Аянгын буулт хийсэн тодорхойлолт ажлын гүйцэтгэсэн далд ажлын акт шалгуулах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Ус сувгийн удирдах газар, Хэрэглэгчдэд үйлчлэх албаны менежер **Г.Үүрийнгэгээ:**

- Унд ахуйн усны нөөцийн савны угаалга, халдваргүйжүүлэлт хийсэн акт шалгуулах /тусгай зөвшөөрөлтэй байгууллагаар хийлгэх/.
- Бохир ус зөөвөрлүүлэх гэрээ хийж, шалгуулах /тусгай зөвшөөрөлтэй байх/
- Гадна гүний худаг, бохир усны худаг, цооногийг хотын мэдээлэлийн санд оруулсан акт шалгуулах /гүйцэтгэлийн зургийг эх хувиар шалгуулах/

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

“Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХК-ийн Технологийн удирдлага төлөвлөлтийн газар Дэд бүтэц төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн **М.Жаргалан:**

- Гадна холбооны оролтын хулгийг онгойлгоход саадгүй болгох, уурын зуух уруу хийсэн сувагчлалыг булаах, мэдээллийн санд туслах
- Хяналтын камерыг бүрэн суурилуулж гүйцэтгэлийн акт үйлдэх
- Зарлан мэдээлэх систем суурилуулж ажиллагаанд оруулаж гүйцэтгэлийн акт үйлдэх
- Холбоо дохиололын гүйцэтгэлийн зураг, бүдүүвч схем хийх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Онцгой байдлын ерөнхий газрын Барилгын зураг төслийн хяналтын ахлах байцаагч, Ахмад **Б.Дөл-Эрдэнэ:**

- Галын дохиоллын гар мэдээлэгч, утаа мэдрэгчийн холболтыг бүрэн гүйцэт хийж ажиллагаанд оруулах
- Гал түймэр унтраах даралтын хоолой, техникийн шаардлага, гал унтраах хоолой хушууны тотго бегданов тотготой болгох /Галын гидрант/
- Агуулахын доторх аврах зам гарцын тэмдэг тэмдэглэгээ хийх
- Өрөө тасалгааны өөрчлөлтийн зургийг дахин магадлалд оруулах
- Барилгын материалын лабораторийн дүгнэлт гэрчилгээг нөхөж үзүүлэх
- Анхааруулах тэмдэг тэмдэглэгээг хийж гүйцэтгэх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Барилга хөгжлийн төв, Барилга, барилгын материал үйлдвэрлэлийн хэлтэс, Барилгын зураг төслийн хяналтын ахлах байцаагч **Д.Батням:**

АЛТ ША
ГАЗА
йгууламж
оруулах к

- Барилгын ажлын зөвшөөрлийн хугацаа 2024.06.24-ны өдөр дууссан сунгалт хийгдээгүй
 - Өрөө тасалгааны хийц бүтээцийг өөрчилсөн бол зургийг магадлалд оруулах
 - Барилгын материалын тохирлын гэрчилгээ дутуу
 - Нормчлолын сангийн төлбөрийг тооцуулан төсөвт хийх
- Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Үндэсний төв архив, Зураг төслийн баримтын архивын ахлах архивч **Э.Шижиртуяа:**

- Ил далд ажлын актыг бүрэн бүрдүүлэх, баталгаажуулах
 - Барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн тэмдэглэлд гүйцэтгэгч байгууллага баталгаа гаргах
 - Архивт баримт бичиг хүлээлгэн өгөх нийтлэг жагсаалтын дагуу баримт бичгийг бүрэн бүрдүүлэх, баримт бичгийн хуудас дугаарлах, дотоод томъёог үйлдэх
 - Баримт бичиг болон ажлын зургийн эх хувийг архивт хүлээлгэн өгөх
- Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад авах саналтай байна.

Ашиглагч байгууллагын төлөөлөл Эл Би Урбан Товер ХХК-ийн менежер **М.Одонхүү:**

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллагын төлөөлөл **Б.Ганбаатар:**

- Нийтийн авто зогсоолд хийсэн ХБХ-ийн машинд зориулсан зогсоолд 1м80см шон 60*60 самбар хийх
- Гадна налуу замын 2 талын бариул налуу замын төгсгөлөөс 30см илүү үргэлжүүлэх
- 1.3 давхарын шүршүүрийн, нэг давхарын 1 өрөөнд туслах бариулыг стандартын дагуу суурилуулах
- 1-3 давхарын ариун цэврийн өрөөний туслах бариулыг стандартын дагуу суурилуулах

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Зураг төслийн “Юнирүүтс” ХХК-ийн захирал **С.Бекжан:**

- Комиссын гишүүдийн үүрэг даалгаварын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Барилгын ажлын захиалагч “Эл Би Урбан Товер” ХХК-ийн захирал **Д.Энхтүвшин:**

- Гишүүдийн өгсөн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Барилгын ажлын гүйцэтгэгч “Титанманлай” ХХК-ийн захирал **Ч.Отгонцагаан:**

- Гишүүдийн өгсөн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

ГАЛТЫН
Р

ийг ашигла
мисс

Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч **Б.Батчимэг**:


- Барилгын тухай хуулийн 14.3, 14.6 заалтын дагуу барилгад чанарын баталгаа албан бичгээр ирүүлэх
- Зохиогчийн тусгай зөвшөөрлийн сунгалт ирүүлэх
- Зураг төслөөс өөрчилсөн ажилд зохиогчоос тайлбар албан бичгээр ирүүлэх
- БНБД 11-04-16 зохиогчийн дүгнэлт шинэчлэж ирүүлэх
- Батлагдсан ерөнхий төлөвлөгөөний дагуу хийгдсэн ажлын гүйцэтгэл зурагаар баримтжуулж ирүүлэх

Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад авах саналтай байна.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хороо, Эл Би Урбан Товер ХХК-ийн захиалгатай зорьгүй 1-3 давхар, 4 блок, 210.0м*60.0м, 12600.0мкв агуулахын зориулалттай барилга, зорьгүй 1 давхар, 28.0м*12.0м уурын зуухны барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын гишүүдийн гаргасан үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, биелэлтээр комиссын дүгнэлт үйлдэх, баталгаажуулах, ашиглалтад оруулахаар **шийдвэрлэв.**

Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч



(Б.Батчимэг)

Нарийн бичгийн дарга:
"Эл Би Урбан Товер" ХХК-ийн захирал



(Д.Энхтүвшин)

Танд